

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АРВАНТАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны тавдугаар сарын 05-ны 14 цаг 10 минутад эхэлж, 14 цаг 27 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 17 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	УИХ-ын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 08 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 05 сарын 05-ны өдрийн хуралдаанаас:</p> <p>Пэлжидийн Амаржаргалыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт санал болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн нутгийн захиргааны байгууллагын болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2016 оны 04 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд</p>

Сүхбаатар аймаг, Говьсүмбэр аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 05 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 16 иргэн /Сүхбаатар аймагт 2, Говьсүмбэр аймагт 14/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 33 иргэн /Сүхбаатар аймагт 10, Говьсүмбэр аймагт 23/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 5 /Сүхбаатар аймагт 2, Говьсүмбэр аймагт 3/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэн иргэн /Сүхбаатар аймагт 5, Говьсүмбэр аймагт 3/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх

3. Энэхүү тогтоолын 5-8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн

23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөл /Ц.Лхамсүрэн/-т, Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл /Б.Батдэлгэр/-д тус тус үүрэг болгох

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 05 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 3 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн

		<p>иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 1 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ш.Эрдэнэбулган/-д үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

